

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:

“ХIII.4.Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ орон нутагт ажилласан талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

Нэг.Орон нутгийн иргэдэд танилцуулж, эрэмбэлсэн болон иргэдээс гаргасан саналд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцсэн байдал, төслийн зураг төсөв, бэлтгэл ажил, гүйцэтгэлийг харгалзан доор дурдсанаар шийдвэрлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч наарт үүрэг болгосугай:

1.1.Монгол Улсын 2024 оны төсөвт тусган шинээр хэрэгжүүлэх доор дурдсан төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгаж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

1.1.1.Архангай аймагт: Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Архангай, Эрдэнэбулаг сум), Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэргийн цагаан нуур хүртэлх хатуу хучилттай авто зам, 13 км (Архангай, Тариат сум), Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор (Архангай, Эрдэнэбулаг сум, 5 дугаар цэцэрлэг), Аймгийн хөгжимт драмын театрын тоног төхөөрөмж (Архангай, Эрдэнэбулаг сум), Ахмадын хөгжлийн өргөөний тоног төхөөрөмж (Архангай, Эрдэнэбулаг сум);

1.1.2.Баян-Өлгий аймагт: Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 22 км, төмөр бетон гүүр, 99.94 у/м (Баян-Өлгий), Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж (Баян-Өлгий, Өлгий сум);

1.1.3.Баянхонгор аймагт: Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Баянхонгор, Баянхонгор сум), Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км (Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум), Сургуулийн барилга, 640 суудал (Баянхонгор, Баянхонгор сум, Соого сейкоо сургууль), Сургуулийн барилга, 250 суудал (Баянхонгор, Жаргалант сум), Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал (Баянхонгор, Баянхонгор сум, Эрдэм сургууль), Цэцэрлэгийн барилга, 280 суудал (Баянхонгор, Баянхонгор сум), Багшийн хөгжлийн ордны барилга (Баянхонгор, Баянхонгор сум), "Цэвэр хот" ОНӨААТҮГ-ын ажилчдын байр, халуун усны байр (Баянхонгор, Баянхонгор сум), Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны барилга, 150 ор (Баянхонгор, Баянхонгор сум), Нийгмийн даатгалын хэлтсийн барилга (Баянхонгор, Баянхонгор сум), Наркологийн төв эмнэлгийн

барилга (Баянхонгор, Баянхонгор сум), Түйн голын төмөр бетон гүүр, 64.75 у/м (Баянхонгор, Богд сум)

1.1.4.Булган аймагт: Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, Хишиг-Өндөр сумын доторх 4 км авто зам (Булган), Сургуулийн барилга, 320 суудал (Булган, Сайхан сум), Төв номын сангийн барилга (Булган, Булган сум), Соёлын төвийн барилга, 240 суудал (Булган, Бүрэгхангай сум), Жаргалант хүүхдийн зуслан (Булган, Бугат сум), Сумын цахилгаан хангамж (Булган, Могод сум), Тусгай хэрэгцээт хүүхдийн яслийн барилга, 60 ор (Булган, Булган сум), Цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих, 100 ор (Булган, Булган сум, 6 дугаар цэцэрлэг), Соёлын төвийн тоног төхөөрөмж (Булган, Бугат сум), Дотуур байрны барилга, 150 ор (Булган, Хангаль сум, Хялганат тосгон);

1.1.5.Говь-Алтай аймагт: Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Говь-Алтай, Тайшир сум), Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Говь-Алтай, Есөнбулаг сум), Сургуулийн барилга, 640 суудал (Говь-Алтай, Есөнбулаг сум, Хантайшир-Эрдэм цогцолбор), Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 15.6 км (Говь-Алтай, Есөнбулаг сум), Аймгийн засаг даргын тамгын газрын тоног төхөөрөмж (Говь-Алтай, Есөнбулаг сум, лед дэлгэц), Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж (Говь-Алтай, Есөнбулаг сум);

1.1.6.Говьсүмбэр аймагт: Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга (Говьсүмбэр, Сүмбэр сум), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар сургууль), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал, (Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр сургууль), Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 120 ор (Говьсүмбэр, Сүмбэр сум, 6 дугаар цэцэрлэг), Политехник коллежийн тоног төхөөрөмж (Говьсүмбэр, Сүмбэр сум), Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц, 2 дугаар хэлхээ (Говьсүмбэр, Сүмбэр сум), Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Чойр-Их залаат овооны ар хүртэлх хатуу хучилттай авто замын эхний үе шат (Говьсүмбэр), Ахмадын өргөөний барилга (Говьсүмбэр, Сүмбэр сум), Ахмадын хамтлагт тоног төхөөрөмж (Говьсүмбэр), Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3.4 км (Говьсүмбэр, Баянтал сум);

1.1.7.Дархан-Уул аймагт: Уерийн байгууламж (Дархан-Уул, Дархан сум), Сургуулийн барилга, 1500 суудал (Дархан-Уул, Дархан сум), Сургуулийн барилга, 480 суудал (Дархан-Уул, Орхон сум), Цэцэрлэгийн барилга, 150 ор (Дархан-Уул, Дархан сум, 14 дүгээр баг), Сургуулийн барилгын өргөтгөл, 960 суудал (Дархан-Уул, Дархан сум, 10 дугаар баг, Оюуны ирээдүй цогцолбор сургууль), Шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам (Дархан-Уул, Дархан сум), Өвлийн спортын ордны барилга (Дархан-Уул, Дархан сум), Хорооллын дулаан хангамж (Дархан-Уул, Дархан сум, 31 дүгээр хороолол), Аймгийн төвийн доторх хатуу хучилттай авто замын 2 дугаар үе шат (Дархан-Уул, Дархан сум), Нэгдсэн эмнэлгийн ангиографийн тоног төхөөрөмж (Дархан-Уул, Дархан сум), Залуус 1, 2 дугаар хорооллын инженерийн шугам сүлжээ, цахилгаан хангамж (Дархан-Уул, Дархан сум);

1.1.8.Дорноговь аймагт: Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл (Дорноговь, Сайншанд сум), Хамарын хийдийн З замын уулзвараас-

Зүүнбаян чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 18.2 км (Дорнговь, Сайншанд сум), Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж (Дорнговь, Замын-Үүд сум), Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга (Дорнговь, Сайншанд сум);

1.1.9.Дорнод аймагт: Чойбалсан хотын ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэл (Дорнод, Хэрлэн сум), Дулааны 1 дүгээр гол шугам ТК-1 худгаас ТК-3 худаг хүртэлх 20400 мм голчтой дулааны магистраль шугамыг 20800 мм голчтой болгох өргөтгөл (Дорнод, Хэрлэн сум), 1000 айлын орон сууцны хорооллын гадна дулаан хангамжийн шугам сүлжээ (Дорнод, Хэрлэн сум, 3 дугаар баг), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Дорнод, Хэрлэн сум, Шинэ Хөгжил сургууль), Бага сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал (Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар сургууль), Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт (Дорнод, Хэрлэн сум);

1.1.10.Дундговь аймагт: Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Дундговь, Сайнцагаан сум), Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга (Дундговь, Сайнцагаан сум), Ахмадын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж (Дундговь), Соёлын төвийн барилга, 250 суудал (Дундговь, Дэлгэрхангай сум), Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Мандалговь-Чойр чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат (Дундговь), Нэгдсэн эмнэлгийн мэс заслын вакум өрөөний тохижилт, тоног төхөөрөмж (Дундговь, Сайнцагаан сум), Соёлын төвийн барилга, 250 суудал (Дундговь, Баянжаргалан сум);

1.1.11.Завхан аймагт: Богд, Чигэстэйн голын төмөр бетон гүүр, 290.03 у/м (Завхан, Улиастай сум), Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Завхан, Улиастай сум), Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал (Завхан, Улиастай сум), Цэцэрлэгийн барилга, 150 ор (Завхан, Улиастай сум), Политехник коллежийн дотуур байрны барилга, 150 ор (Завхан, Улиастай сум), Хөгжим бүжгийн коллежийн дотуур байрны барилга, 150 ор (Завхан, Улиастай сум);

1.1.12.Орхон аймагт: Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл, 92.13 км (Орхон, Дархан-Уул, Төв), Сургуулийн барилга, 960 суудал (Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол), Сургуулийн барилга, 960 суудал (Орхон, Баян-Өндөр сум, Дэнж баг, 7 дугаар хороолол), Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Орхон, Баян-Өндөр сум, Дэнж баг), Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Орхон, Баян-Өндөр сум), Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор (Орхон, Баян-Өндөр сум, Ирээдүйн одод сургууль), Стандарт, хэмжил зүйн хэлтсийн тоног төхөөрөмж (Орхон, Баян-Өндөр сум);

1.1.13.Өвөрхангай аймагт: Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Өвөрхангай, Арвайхээр сум), Гэр хорооллын шугам сүлжээ (Өвөрхангай, Арвайхээр сум), Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Хужирт сум хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл, 43.3 км (Өвөрхангай, Хужирт сум), Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга, 150 ор (Өвөрхангай, Арвайхээр сум, 13 дугаар баг), Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхимиын хамт (Өвөрхангай, Есөнзүйл сум), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга (Өвөрхангай, Арвайхээр сум), Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Арвайхээр-

Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат (Өвөрхангай), А0302 авто замаас Хайрхандулаан сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.8 км (Өвөрхангай, Арвайхээр сум), Сургуулийн барилга, 320 суудал (Өвөрхангай, Хархорин сум), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Өвөрхангай, Арвайхээр сум, 2 дугаар сургууль), Татварын хэлтсийн барилгын их засвар (Өвөрхангай, Арвайхээр сум);

1.1.14.Өмнөговь аймагт: Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто зам, 80 км (Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум);

1.1.15.Сүхбаатар аймагт: Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м (Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум), Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Сүхбаатар, Баруун-Урт сум), Дарьганга зуслангийн гадна инженерийн шугам сүлжээ (Сүхбаатар, Дарьганга сум);

1.1.16.Сэлэнгэ аймагт: Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 10.3 км (Сэлэнгэ, Мандал сум), Төмс, хүнсний ногооны зоорь, 500 тн, 1000 тн (Сэлэнгэ, Сүхбаатар, Мандал, Баянгол, Шаамар сум), Соёлын төвийн барилга, 400 суудал (Сэлэнгэ, Хүдэр сум), Соёлын төвийн барилга, 400 суудал (Сэлэнгэ, Ерөө сум), Сургуулийн барилга, 640 суудал (Сэлэнгэ, Мандал сум, 2 дугаар сургууль), Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор (Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхан тосгон), Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 6.3 км (Сэлэнгэ, Сүхбаатар сум), Ерөө сумын төвөөс Бугант чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 27.8 км (Сэлэнгэ, Ерөө сум);

1.1.17.Төв аймагт: Гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээ (Төв, Зуунмод сум, 6 дугаар баг), Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал (Төв, Зуунмод сум, Хүмүүн цогцолбор сургуулийн А байр), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Төв, Зуунмод сум, 5 дугаар сургууль), Цагдаагийн газрын барилга (Төв, Зуунмод сум), Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Төв, Зуунмод сум);

1.1.18.Увс аймагт: Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км (Увс), Турууны голын төмөр бетон гүүр, 109.15 у/м, Бухын голын 9.6 у/м гүүр, 1.1 км авто зам (Увс, Баруунтуруун сум), Сургуулийн барилга, 320 суудал (Увс, Бөхмөрөн сум), Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг (Увс), Дотуур байрны барилга, 160 суудал (Увс, Өмнөговь сум, 5 дугаар баг), Ерөнхий боловсролын сургуулийн олон улсын стандарт хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байр, спорт цогцолборын барилга (Увс, Улаангом сум, 1 дүгээр сургууль), Ахмадын төвийн тоног төхөөрөмж (Увс, Сагил сум);

1.1.19.Ховд аймагт: Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр (Ховд, Жаргалант сум), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Ховд, Жаргалант сум, 2 дугаар баг, 7 дугаар сургууль), Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох хатуу хучилттай авто зам, 32.4 км (Ховд, Дарви сум), Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 40.7 км (Ховд, Дөргөн сум), Цэцэрлэгийн барилга, 150 ор (Ховд, Жаргалант сум, 5 дугаар баг, 6 дугаар цэцэрлэг), Цэцэрлэгийн барилга, 150 ор (Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, 4 дүгээр цэцэрлэг), Цэцэрлэгийн барилга, 240 ор

(Ховд, Жаргалант сум, 7 дугаар баг, 2 дугаар цэцэрлэг), Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ (Ховд, Жаргалант сум), Дулааны станцын шинэчлэл (Ховд, Жаргалант сум);

1.1.20.Хөвсгөл аймагт: Цэцэрлэгийн барилга, 150 ор (Хөвсгөл, Мөрөн сум, 8 дугаар цэцэрлэг), Дулааны станцын өргөтгөл, 21 МВт (Хөвсгөл, Мөрөн сум), Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал (Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон), Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал (Хөвсгөл, Мөрөн сум, Эрдмийн далай цогцолбор сургууль), Хөгжимт драмын театрын барилга, 890 суудал (Хөвсгөл, Мөрөн сум), Политехник коллежийн цогцолборын барилга, 800 суудал (Хөвсгөл, Мөрөн сум), Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилга (Хөвсгөл, Мөрөн сум), Дотуур байрны барилга, 240 ор (Хөвсгөл, Галт сум), Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Хөвсгөл, Мөрөн сум, Гурван-Эрдэнэ сургууль), Сургуулийн барилга, 320 суудал (Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум), Цэцэрлэгийн барилга, 100 ор (Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон), Ахмад настны асрамж, үйлчилгээний төвийн барилга (Хөвсгөл, Мөрөн сум), Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор (Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон), Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор (Хөвсгөл, Мөрөн сум), Аялал жуулчлалын "Хүслийн хад" цогцолбор (Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон);

1.1.21.Хэнтий аймагт: Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 127.5 км (Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум), Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км (Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум), Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн хатуу хучилттай авто зам, 59.2 км (Хэнтий, Жаргалтхаан, Дэлгэрхаан сум), Хатуу хучилттай авто зам, 4.1 км (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон), Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км (Хэнтий, Хэрлэн сум), Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум, 3, 4, 5 дугаар баг), Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц (Хэнтий, Хэрлэн сум), Залуучуудын сургалт, спорт хөгжлийн төв (Хэнтий, Бор-Өндөр сум), Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, шинэчлэл (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон).

1.2.Ургэлжлэн хэрэгжих доор дурдсан төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгаж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

1.2.1.Архангай аймгийн хөгжимт драмын театрын барилга (Архангай, Эрдэнэбулган сум);

1.2.2.Дархан-Уул аймагт спорт цогцолбор, 2200 суудал (Дархан-Уул, Дархан сум);

1.2.3.Дундговь аймагт Шинэ сум төсөл (Дундговь, Луус сум), Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал (Дундговь, Сайнцагаан сум) Хүмүүнлэг сургууль, Сургуулийн барилга, 960 суудал (Дундговь, Сайнцагаан сум, Говийн ирээдүй цогцолбор);

1.2.4.Сүхбаатар аймагт Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц (Сүхбаатар);

1.2.5.Сэлэнгэ аймагт Жишиг сум (Сэлэнгэ, Алтанбулаг сум);

1.2.6.Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км (Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум), Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ор (Төв, Зуунмод сум);

1.2.7.Увс аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрны барилга (Увс, Улаангом сум);

1.2.8.Ховд аймагт "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт (Ховд, Жаргалант сум), "Ховд дулааны станц"-ын өргөтгөл (Ховд).

1.3.Нэмэлт санхүүжилт шаардлагатай, Үндэсний аудитын газрын дүгнэлт гарсны дараа Монгол Улсын 2024 оны төсөвт тусган хэрэгжүүлэх Говьсүмбэр аймгийн Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга (Говьсүмбэр), Дундговь аймгийн "Төв халх" дуулалт жүжгийн театр (Дундговь, Сайнцагаан сум), Төв аймгийн Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл (Төв, Зуунмод сум), Увс аймгийн Оюутны дотуур байрны барилга, 300 ор (Увс, Улаангом сум, Политехник коллеж), Усан бассейн, спорт фитнесийн барилга (Увс, Улаангом сум), Хөвсгөл аймгийн Спорт, урлагийн (Авъяас) цогцолбор сургууль, 320 суудал (Хөвсгөл, Мөрөн сум) зэрэг төсөл, арга хэмжээг аудитын дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгаж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

1.4.Доор дурдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулахад шаардагдах зардлыг 2024 оны төсвийн зохих багцаас санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт;

1.4.1.Архангай аймагт: Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц, Хүүхэд, залуучуудын нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх цогцолборын барилга;

1.4.2.Баян-Өлгий аймагт: Өлгий нисэх буудлын аэродромыг олон улсын иргэний нисэхийн байгууллагын 4С ангилалтай болгох, Цэнгэл сум-Даян боомт чиглэлийн 117 км хатуу хучилттай авто зам;

1.4.3.Баянхонгор аймагт: Хүүхдийн ордны барилга, Хөдөө аж ахуйн коллежийн барилга;

1.4.4.Булган аймагт: Бугат-Булган чиглэл хатуу хучилттай авто зам, 24 км, Цагдаагийн газрын барилга, Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга, Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний зураг төсөв, 35 кВ, Булган аймгийн Тэшиг sumaас Бага-Илэнхийн хилийн боомт хүртэлх 80 км хатуу хучилттай авто зам;

1.4.5.Говь-Алтай аймагт: Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга, аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгад вакум мэс заслын өрөөг нэмэлтээр байгуулах, Арцсуурь, Бургастай боомтын авто зам;

1.4.6.Дархан-Уул аймагт: Дархан-Зулзагын гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 20 км);

1.4.7.Дорноговь аймагт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилга, аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Цогцолборын барилга;

1.4.8.Дорнод аймагт: Чойбалсан хотоос Баянхшуу боомт, Халх гол чиглэлийн авто зам, 210 км, Цэцэрлэгийн барилга, 240 ортой;

1.4.9.Дундговь аймагт Түмний хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажил, Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн ажлыг үргэлжлүүлэх, Цэгц билиг дунд сургуулийн өргөтгөл, дотуур байр;

1.4.10.Завхан аймагт: Хүүхэд, залуучуудын соёл амралтын хүрээлэн, Нэмрөг-Улаангом чиглэлийн A18 дугаартай авто замаас Арцсуурь боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам;

1.4.11.Орхон аймагт: Тусгай хэрэгцээт иргэдийн хөгжлийн төвийн барилга;

1.4.12.Өвөрхангай аймагт: Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал овоо чиглэлийн авто зам, 250 км, Арвайхээр-Гучин-Ус-Шивээхүрэн чиглэлийн авто зам, Сургуулийн биеийн тамирын талбай, 8 сургуульд (Аймгийн хэмжээнд), Хүүхдийн зуслан, Багшийн хөгжлийн ордон;

1.4.13.Өмнөговь аймагт: Даланзадгадын дулааны цахилгаан станцын нэгдүгээр зуухны хүчин чадлыг нэмэгдүүлэх, Улааннуур-Даланзадгад-Тавантолгой чиглэлийн ус дамжуулах шугам хоолой;

1.4.14.Сэлэнгэ аймагт: Хөдөө аж ахуй, био технологийн их сургуулийн барилга, Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээний шинэчлэл;

1.4.15.Төв аймагт: Зуунмод хотоос Бүрэн сум хүртэлх авто зам, Залуучуудын цэцэрлэгт хүрээлэн;

1.4.16.Увс аймагт: Улаангом-Баруун Туруун сумын авто зам;

1.4.17.Ховд аймагт: Олон ястны өв соёлын цогцолбор музейн барилга, Спорт цогцолборын барилга, Дуут, Мөнххайрхан сумдыг холбосон хатуу хучилттай авто замын техник, эдийн засгийн үндэслэл бэлэн болсны дараа улсын төсөвт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх;

1.4.18.Хөвсгөл аймагт: Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Хөвсгөл аймгийн Мөрөн сум-Архангай аймгийн Тариат сумын Тэргийн цагаан нуур чиглэлийн хатуу хучилттай авто зам, Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн Хатгал-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто замаас Ханх сум хүртэлх хатуу хучилттай авто зам, Хөвсгөл аймгийн төвд фитнес төв бүхий 5 замтай усан бассейн барих, Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын барилга;

1.5.Гадаадын зээл тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх Алтай-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам, 198 км, Байдрагийн усан цахилгаан станц барих төсөл арга хэмжээ, A0502 дугаартай Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын 271-298 км хоорондох 27 км хатуу хучилттай авто замын их

засвар, шинэчлэлт (Дорнод, Булган сум), Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн A0502 дугаартай улсын чанартай авто замын км 50+000-км 100+000-ийн хооронд 50 км авто замын их засвар (Хэнтий, Дорнод), Улсын чанартай авто замтай холбох хатуу хүчилттай авто зам, 14.7 км (Өвөрхангай, Есөнзүйл сум), Ховд-Улаангом чиглэлийн 163.3 км хатуу хүчилттай авто зам (Ховд, Увс), Увс аймагт Цаг уурын радар байгуулах зэрэг төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээ авч шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан болон холбогдох Засгийн газрын гишүүдэд;

1.6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тухайн орон нутгийн 2024 оны төсөвт тусган хэрэгжүүлэх доор дурдсан төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс 2024 онд хэрэгжүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт;

1.6.1. Баянхонгор аймгийн 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар (Баянхонгор сум), Хүүхдийн зуслангийн их засвар;

1.6.2. Дархан-Уул аймгийн Цэцэрлэгийн засвар;

1.6.3. Дорноговь аймгийн 1 дүгээр сургуулийн барилгын засвар;

1.6.4. Орхон аймгийн Сургуулийн барилгын их засвар (Орхон, Баян-Өндөр сум, 14 дүгээр сургууль);

1.6.5. Өвөрхангай аймгийн Багшийн хөгжлийн ордны барилгын санхүүжилтийн 50 хувь (Өвөрхангай, Арвайхээр сум), Халамж үйлчилгээний барилга (Арвайхээр сум);

1.6.6. Өмнөговь аймгийн Ахмадын сувиллын барилга, 44 ор (Өмнөговь, Даланзадгад сум);

1.6.7. Увс аймгийн Улаангом сумын арын 4 замын уулзвараас тойрог цагаан хаалга хүртэлх авто замын шинэчлэл, гэрэлтүүлэг;

1.6.8. Ховд аймгийн Цэцэрлэгийн барилгын их засвар (Ховд, Жаргалант сум, 2, 3, 4 дүгээр цэцэрлэг).

1.7. Орхон аймагт Хатуу хүчилттай авто замын завсар (Орхон), Сэлэнгэ аймагт Дулааны станц (Сэлэнгэ), Шинэ суурьшлын бүсийн дэд станц (Сэлэнгэ, Сүхбаатар сум), Завхан аймагт Арц суурь-Шивээ хүрэн чиглэлийн 1255 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, Өмнөговь аймагт Гурвансайхан нисэх буудлын аэродромын өргөтгөл, навигацийн тоног төхөөрөмж (Өмнөговь, Даланзадгад сум), Хилийн боомтод харилцаа, холбооны үйлчилгээ хүргэх төсөл (Өмнөговь, Гурвантэс сум) зэрэг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хуулийн хүрээнд шуурхай хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт;

1.8. Булган аймгийн Цогтын цагаан балгасыг сэргээн засварлах, Дундговь аймгийн шинээр баригдсан нэгдсэн эмнэлгийн хажуугийн хуучин барилгыг худалдан авах (газар чөлөөлөх зорилгоор) санхүүжилт, Төв аймгийн

Зуунмод сумын спортын төрөлжсөн сургуулийн барилгын үлдэгдэл болон нэмэлт санхүүжилт, Зуунмод сумын Зүүндэлгэр багийн цахилгаан хангамжийг сайжруулах зэрэг төсөл, арга хэмжээнд шаардагдах зардлыг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, 2023 онд багтаан хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд;

1.9.Монгол Улсын 2023 оны төсөвт тусгагдсан Говь-Алтай аймгийн Бургастай боомтын зураг төсөл (Говь-Алтай), Дархан-Уул аймагт 20 нийтийн тээврийн автобус, Хөвсгөл аймгийн Хүүхдийн эмнэлгийн барилга, 100 ор (Хөвсгөл, Мөрөн сум) зэрэг төсөл, арга хэмжээг 2023 онд багтаан дуусгах арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд.

Хоёр.Орон нутгийн иргэд, байгууллагаас гаргасан санал, хүсэлт, тулгамдаж байгаа асуудлыг судлан, шийдвэрлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд үүрэг болгосугай:

2.1.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах, газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, төрийн үйлчилгээ авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын тамгын газрын орон тооны дээд хязгаарыг дахин шинэчлэх асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд;

2.2.Авлигатай тэмцэх “5 Ш” ажиллагааны хэрэгжилтийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;

2.3.Булган, Говь-Алтай, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудад авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд хяналт шалгалт хийж, дунг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд;

2.4.Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулж танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт;

2.5.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн дамжуулан зээлдүүлэх зээлийн үлдэгдэл, эргэн төлөлт, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган зохих арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд;

2.6.Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт;

2.7.Хүүхдийн хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авч байгаа зохицуулалтыг өөрчлөх боломжийг судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

2.8.Монгол Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник хэрэгсэл (дрон), дэвшилтэй технологийг ашиглах, хилийн торыг шинэчлэх, камержуулах ажлыг эрчимжүүлэх, хил дамнасан малын хулгайг зогсоох тухай асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар;

2.9.Бичил уурхай эрхлэгчдийн талаар судалгаа хийж, шийдвэрлэх саналаа танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар болон Ерөнхий сайдын ажлын алба (Д.Амгаланбаатар)-нд;

2.10.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дийлэнх хувийг тухайн аймаг, сумын төсөвт төвлөрүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт;

2.11.Барилгын материалын үнийн өсөлтөөс шалтгаалсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэж байгаа асуудлыг шийдвэрлэх талаар зохих арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.12.Аймгийн төвөөс 10-50 км зайд байрлах сумдыг нэгтгэх, татан буулгах, аймгийн төвийн сумдын хилийн цэсийг тэлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт;

2.13.Орон нутагт ажиллах хүний нөөц бэлтгэх ажлыг бодлогоор дэмжиж, орон нутгийн төрийн албан хаагчдыг гадаадад суралцахад дэмжлэг үзүүлэх, англи хэлний сургалтад хамруулах, бусад улс орны туршлага судлах албан томилолтоор ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлэх талаар зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт;

2.14.Залуучуудын талаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа нарт;

2.15.Багш бэлтгэх сургалтын тогтолцоо, агуулгыг (босго оноог дээшлүүлэх, англи хэлний курс болон гадаадад сургах) судлан үзэж, арга хэмжээ авах, багш, эмч, малчдын боловсролыг дэмжих чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;

2.16.Нийгмийн даатгалын бүрэн тэтгэврийн доод хэмжээ, тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжийг судлах, хөдөлмөрийн дэвтрэйг тэтгэвэр тогтоолгох баримт бичигт хамруулах эрх зүйн үндэслэл байгаа эсэхийг судлан шийдвэрлэх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ыг хянан үзэх, шинэчлэх асуудлыг судлан шийдвэрлэхийг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.17.Ахмад настнуудыг орон байраар хангах, ахмадын амжилт, хөдөлмөрийг үнэлэх асуудлыг бодлогоор дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяд;

2.18.Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан стандартын шаардлага хангаагүй барилга, байгууламж барьсан, байнгын ашиглалтад оруулсан аж ахуйн нэгжийн тендерийн үнэлгээний оноог хасах эрх зүйн зохицуулалтыг холбогдох журамд тусган өөрчилж, мөрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.19.Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийг төрийн худалдан авах үйл ажиллагаанд оролцоход нь дэмжих зохицуулалтыг судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.20.Нийтлэг үйлчилгээний салбарын ажилтнууд, нягтлан бодогч, нярав, цаг уурын ажилтны цалин, хөлсийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг тогтворт суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх боломжийг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.21.Залуу малчдын улсын зөвлөгөөнийг зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, залуу малчдыг дэмжих бодлого боловсруулж, танилцуулахыг Уvs аймгийн Засаг дарга Ч.Чимэд нарт;

2.22.Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

2.23.Өвлийн хүлэмж барихад зориулж хөнгөлөлттэй зээл олгох, оюутан, ахлах ангийн сурагчдыг намрын ногоо хураах ажилд оролцуулах асуудлыг судалж, шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;

2.24.Газар тариаланчдын үр тария тариалах зориулалтаар авсан 3 хувийн зээлийн эргэн төлөлтийг 3 жилийн хугацаагаар хойшлуулах асуудлыг судлан, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт;

2.25.Эрүүл мэндийн даатгалаар олгогддог хөнгөлөлттэй эмийн чанарыг сайжруулах, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулан иргэдэд хүндрэлгүй байдлаар зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;

2.26.Орон нутгийн эмч, сувилагч нарын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор гадаадын өндөр хөгжилтэй оронд туршлага судлах боломжийг судалж, тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;

2.27.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээг судлан үзэж, шаардлагатай тоног төхөөрөмжийн 2023 оны батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;

2.28.Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

2.29.Архангай аймгийн Эрдэнэбулган сумын “Хүүхэд, залуучууд, нийтийн биеийн тамирын цогцолбор” төслийг улсын төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

2.30.Баянхонгор аймгийн Баянхонгор сумын иргэн С.Бямбадоржийн хүсэлтийг дэмжиж гадаадын судлаач, эрдэмтдийг ирүүлэх зардлыг олгож, дэмжлэг үзүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;

2.31.Баянхонгор аймгийн Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэ Монгол” ХХК-ийн уурхайтай холбоотой асуудлыг судалж, шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг томилж ажиллуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатарт;

2.32.Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ашиглаж байсан байрыг Стандарт, хэмжил зүйн хэлтэст шилжүүлэх асуудлыг “Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” Засгийн газрын 2023 оны 109 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулж, шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;

2.33.Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдэд үйлчлэх төвийн барилгыг шинээр эхлүүлэх, Баянхонгор аймгийг хилийн боомтой холбох, эдийн засгийн хөгжлийг дэмжих чиглэлээр бус нутгийн хэмжээнд бусад аймагтай хамтарч ажиллахыг аймгийн Засаг дарга Д.Мөнхсайханд;

2.34.Булган аймгийн Тэшиг сумын цахилгаан дамжуулах шугам сүлжээг өргөтгөх асуудлыг судлан танилцуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд;

2.35.Булган аймгийн Тэшиг сумын Бага-Илэнх хилийн боомтын үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлыг судалж танилцуулахыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт;

2.36.Говь-Алтай аймгийг хөгжүүлэх урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулж, хэрэгжүүлэхийг Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт;

2.37.Шивээ-Овоо ХХК-ийн хуримтлагдсан өрийн асуудлыг судлан, санал боловсруулж танилцуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;

2.38.Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн 200 мегаваттын дулааны цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгон батлуулах, дулааны цахилгаан станц барих асуудлыг судалж танилцуулахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;

2.39.Дорнговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Баянбогд хайрхан, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл, Хөнжилийн уулыг улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд;

2.40.Дорнговь аймгийн Замын-Үүд сум дахь автотээврийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, улсын хилээр орж, гарч байгаа авто тээвэрт холбогдох асуудлыг судалж, ойрын хугацаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод;

2.41.Дорнговь аймгийн иргэн Х.Данzanравжаагийн өвөг эцгийн хэлмэгдсэн талаарх хүсэлтийг шалгаж, шийдвэрлэхийг Дорнговь аймгийн Засаг дарга О.Батжаргалд;

2.42.“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн улс, орон нутагт өгөх үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар судлан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.43.Дорнод аймгийн Халх гол сумын төвлөрсөн халаалтын зуухыг шинэчлэхэд шаардлагатай санхүүжилтийг үе шаттай шийдвэрлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд;

2.44.Дорнод аймгийн Хэрлэн сумын 7 дугаар багийн иргэн С.Мишигмаагийн “Хивс” ХХК-ийн 800 иргэний хувьцааны талаарх хүсэлтийг судлан хариу өгөхийг Сангийн сайд Б.Жавхланд;

2.45.Төрийн өмчийн их, дээд сургуулиудыг Улаанбаатар хотоос үе шаттайгаар гаргах, тэдгээрийн орон нутаг дахь салбар, харьяа сургуулийн үйл ажиллагааг дэмжих, Дорнод аймагт сувилагчийн сургуулийг шинээр байгуулах, аймгийн төвд барих цэцэрлэгийн зураг, төслийг 360 хүүхдийн багтаамжтай байхаар тооцож шинэчлэх асуудлыг судлан шийдвэрлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;

2.46.Дорнод аймгийн Хэрлэн суманд баригдаж байгаа “Эрхэс” хорооллын цахилгааны дэд станцыг байгуулах асуудлыг судлан, санхүүжилтийг шийдвэрлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд, мөн аймгийн Хэрлэн сумын 8 дугаар багт халуун усны барилгыг шинээр барих хөрөнгийг 2024 онд орон нутгийн төсөвт тусгаж, мөн ондоо багтаан ашиглалтад оруулахыг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд;

2.47. Тариаланчдад зориулан олгож байгаа дизель түлшний хөнгөлөлтөд хадланчдыг хамруулах, Дорнод аймагт үйлдвэр технологийн парк байгуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;

2.48. Дорнод аймгийн Чойбалсан хот дахь бүсийн оношилгоо, эмчилгээний төвд шаардлагатай томографын аппаратыг шинэчлэх асуудлыг 2023 онд багтаан шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;

2.49. Дундговь аймгийн нутагт дэвсгэрт идлэг шонхор шувуу барих, гадаад улсад гаргах квотыг цуцлах хүсэлтийг судлан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт;

2.50. Салхитын мөнгөний орд болон уурхайн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;

2.51. Дундговь аймгийн Сайнцагаан суманд болсон үерийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг эрчимжүүлэх, хохирсон иргэдэд шаардлагатай туслалцаа үзүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбатад;

2.52. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай холбоотой ажлын байрны дарамт, удирдлагуудын болон ажилтан, ажилчдын цалингийн хэт зөрүүтэй байдал, үйлдвэрийн харьяа орон сууцны хувьчлал, “Уурхайчин-2” орон сууцны төслийн явц, дүн зэрэг асуудлаар Ажлын хэсэг байгуулан ажиллуулан, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;

2.53. Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын тамгын газрын барилгыг шинээр барих санхүүжилтийг судалж үе шаттайгаар улсын төсөвт тусган шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт;

2.54. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Говил багийн иргэн Б.Майнбаярын тавьсан “Эрдэнэт гурил” ХХК-ийн тухай асуудлыг судалж шийдвэрлэхийг Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргалд, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Оюут багийн иргэн А.Бадамцэцэгийн тавьсан орон байрны тухай хүсэлтийг судалж, шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал Г.Ёндөн нарт, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Уртын гол багийн иргэн Д.Ганболдын тавьсан авлигатай холбоотой асуудлыг судалж, шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт;

2.55. “Анхдагч илгээлтийн эзэд” ТББ-аас тавьсан хүсэлтийг судалж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал Г.Ёндөнд;

2.56. Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрэм, журмыг салбарын бодлоготой уялдуулан боловсруулж ажиллахыг Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргалд;

2.57. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын улсын төсөвт төвлөрүүлдэг эх үүсвэрээс 50,0 (тавин) тэрбум хүртэлх төгрөгийг Орхон аймаг, Эрдэнэт хот доторх авто замын засвар, шинэчлэлийн ажилд зориулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ерөнхий захирал Г.Ёндөн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт;

2.58. Орхон аймагт орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг 20,0 (хорин) тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлж батлан Орхон аймаг, Эрдэнэт хотын нийтийн тээврийн автобусыг нэмэгдүүлж шинэчлэх, Баян-Өндөр сумын Дэнж, Оюут багт нэгдсэн төв барих асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргал нарт;

2.59. Өвөрхангай аймгийн 2023 онд багтаж ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, ширээ сандал, зөөлөн эдлэлийг нийлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;

2.60. Өвөрхангай аймгийн Багшийн хөгжлийн ордны барилгын санхүүжилтийн 50 хувийг техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв бэлэн болсны дараа үе шаттайгаар санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

2.61. Өвөрхангай аймгийг “Цахим, жишиг аймаг” хөтөлбөрт хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;

2.62. Хүүхдийн зуслан барих газрыг олгох, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийг дэмжих, өмгөөллийн үйлчилгээний өрөөг стандартын дагуу тохижуулах, сууц өмчлөгчдийн холбооны ажилчдын цалингийн асуудлыг судалж шийдвэрлэхийг Өвөрхангай аймгийн Засаг даргын орлогч И.Доржсүрэнд;

2.63. Өвөрхангай аймгийн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулдаг үйлдвэрүүд дунд ашиглагдах Магадлан итгэмжлэгдсэн лаборатори байгуулж, тоног төхөөрөмжөөр хангах, “Өв Эко мийт” орон нутгийн өмчтэй махны үйлдвэрт шаардлагатай байгаа нэмэлт тоног төхөөрөмжийг нийлүүлэх, мах, ноос, арьс, шир боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулах, борлуулалтыг нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд;

2.64. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 9 дүгээр багийн ахмад настан Б.Бямбадоржийн Улаанбаатар хотод англи хэлний шилдэг сургалтын төвд нэг улирал суралцах сургалтын болон байрны зардлыг олгох асуудлыг судалж, дэмжлэг үзүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;

2.65.Төв аймгийн Зуунмод хотын ерөнхий боловсролын 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургуулийн барилгын ажлын гүйцэтгэлийн дутуу болон (магадлалаар баталгаажсан) нэмэлт зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргаж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд;

2.66.Төв аймгийн "Хүмүүн" цогцолбор сургуулийн Б байрны их засвар, дотуур байрны (А байр-80 хүүхэд, Б байр-100 хүүхэд) их засвар, ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн барилгын их засвар, "Ирээдүй" цэцэрлэгийн А, Б байрны засвар, "Унагалдайн андууд" цэцэрлэгийн гадна засвар, тохижилт зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг 2024 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсвөөс үе шаттай хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт;

2.67.Төв аймгийн Зуунмод сумын багуудын гэр хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээг улсын төсвийн төлөвлөгөөнд тусган, үе шаттай хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэнд;

2.68.Төв аймгийн Зуунмод сумын Зүүндэлгэр багийн цахилгаан хангамжийг сайжруулахад шаардлагатай санхүүгийн (300.0 гаруй сая.төг) эх үүсвэрийн тооцоог хийж Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах арга хэмжээг авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт;

2.69.Төв аймгийн иргэн Н.Эрдэнийн гаргасан хүсэлтийн дагуу аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн нөхцөл байдлыг судлан зохих арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;

2.70.Төв аймгийн Зуунмод сумын "Иргэний танхим"-ыг сэргээн ашиглалтад оруулах, мөн сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн их засварыг орон нутгийн төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарт;

2.71.Богдхан төмөр замын төслийн хэрэгжилт, Багануурын нүүрсний уурхайг түшиглэн ахуйн хий үйлдвэрлэх төсөл, арга хэмжээг судалж иргэн Б.Тойвгоод хариу өгөхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт;

2.72.Шинэ бүтээлийн гэрчилгээ авсан иргэн З.Ариунболдын дулааны нөөцлүүртэй цахилгаан халаагуурыг үйлдвэрлэх, аймаг, сумдад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт;

2.73."Байгалийн түүхийн музей" болон Төв аймгийн "Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей", лабораторийн барилгын гэрээний үлдэгдэл санхүүжилт болон нэмэлт зардлыг 2024 оны улсын төсөвт тусгах, тус төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцтай уялдуулан Соёлын сайдын төсвийн багцын батлагдсан дүнд багтаан зохих журмын дагуу зохицуулалт хийхийг Сангийн сайд Б.Жавхлан, Соёлын сайд Ч.Номин нарт;

2.74.Чацарагынын үйлдвэр барих хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид татварын болон гаалийн хөнгөлөлт үзүүлэх, тоног төхөөрөмжийн урт хугацааны

хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг судлан үзэж, шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;

2.75.Увс аймгийг улсын хэмжээний хөдөө аж ахуйн жишиг бүс болгох талаар судалж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчуулун, Увс аймгийн Засаг дарга Ч.Чимэд нарт;

2.76.Увс аймгийн Улаангом сумын Дулааны хоёрдугаар цахилгаан станцын үйл ажиллагааны талаар иргэдээс гарсан гомдлыг судалж, арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд;

2.77.Увс аймгийн ахмадын холбоотой холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж ажиллахыг Увс аймгийн Засаг дарга Ч.Чимэдэд;

2.78.Төрийн албан хаагчдыг томилох, чөлөөлөхтэй холбоотой гомдлыг 30 хоногийн дотор хуульд нийцүүлэн эцэслэн шийдвэрлэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт танилцуулахыг Увс аймгийн Засаг дарга Ч.Чимэдэд;

2.79.“Халzan Бүргэтэй” төслийн талаар Ховд аймагт үүсээд байгаа нөхцөл байдлыг судлан шийдвэрлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт;

2.80.Ховд аймгийн Жаргалант суманд сургуулийн автобус худалдан авах асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран шийдвэрлэхийг Ховд аймгийн Засаг дарга Э.Болормаад;

2.81.Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд шаардлагатай байгаа иммунологийн бүрэн автомат анализаторыг 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;

2.82.Ховд аймгийн “Бадамлах дөл” ХХК-ийн өмч хувьчлалын асуудлыг судлан шийдвэрлэхийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнд;

2.83.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Ховд аймгийн иргэдтэй холбоотой асуудлыг нарийвчлан судалж, төрөл төрөгсдөд нь тодорхой мэдээлэл өгөхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт;

2.84.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Шинэ Мөрөн” хорооллын оршин суугчдын төлөөллөөс тавьсан хүсэлтийг судалж, холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Хөвсгөл аймгийн Засаг дарга П.Лхагважав нарт;

2.85.Хөвсгөл-Архангай чиглэлийн босоо тэнхлэгийн авто замыг барих ажлыг эхлүүлэх арга хэмжээг авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод;

2.86.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Авьяас” сургуулийн хөгжмийн тоног, төхөөрөмжийн санхүүжилтийг 2024 оны төсвийн төсөлд тусгах, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ сумын сургуулийн барилгын явц, хэрэгжилттэй холбоотой асуудлыг судалж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Соёлын сайд Ч.Номин нарт;

2.87.Хөвсгөл аймгийн Хүүхдийн эмнэлгийн барилгын үлдэгдэл санхүүжилтийг 2024 оны улсын төсөвт тусган шийдвэрлэхийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Сангийн сайд Б.Жавхлан, нарт;

2.88.Хөгжимт драмын театрын үйл ажиллагааг өргөжүүлэн “Хөвсгөл далай” уран бүтээлийн нэгжийг байгуулж, шинээр 25 хүртэлх уран бүтээлчийн цалингийн сан, тоног төхөөрөмж болон Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэн Б.Энхтувшингийн тавьсан хөгжмийн зэмсгийн талаарх хүсэлтийг судалж, шийдвэрлэхийг Соёлын сайд Ч.Номинд;

2.89.“Бэлтэс Мөрөн” ХХК-тай холбоотой асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт;

2.90.Хөвсгөл аймгийн Ханх сумын эрчим хүчний хүчдэл сайжруулахад шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт үе шаттайгаар тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нарт;

2.91.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар багийн цэвэр усны шугам сүлжээг дахин засварлах, дулааны шугам татах, Биеийн тамир, спортын газрын засварын ажлыг судалж, холбогдох зардлыг улсын төсөвт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ нарт;

2.92.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд Онцгой байдлын галын депо барих асуудлыг судалж, орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэхийг Хөвсгөл аймгийн Засаг дарга П.Лхагважавт;

2.93.Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр нийслэл, дүүргийн удирдлага, хороодын Засаг дарга, хорооны хэсгийн ахлагч нартай, 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэдтэй хийсэн уулзалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт;

2.94.Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР